



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Галуут сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БНА-2026/034/НА-СТА-ОНТС

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2026.02.25

2026

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитор: Н.Батчимэг
Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

1.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>484,285,750.00</u>	<u>499,728,650.00</u>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	<u>30,465,000.00</u>	<u>30,465,000.00</u>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	465,000.00	26,401,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,000,000.00	10,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>453,820,750.00</u>	<u>463,327,350.00</u>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	16,656,350.00	49,911,950.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	437,164,400.00	413,415,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>386,958,729.20</u>	<u>484,122,457.28</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>386,958,729.20</u>	<u>484,122,457.28</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>386,958,729.20</u>	<u>484,122,457.28</u>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	386,958,729.20	484,122,457.28
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>97,327,020.80</u>	<u>15,606,192.72</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	97,327,020.80	15,606,192.72
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	171,103,454.55	268,430,475.35
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	268,430,475.35	284,036,886.07

1.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	120,957,754.55	00.00	120,957,754.55
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	120,957,754.55	00.00	120,957,754.55
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	142,712,120.80	00.00	142,712,120.80
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	263,669,875.35	00.00	263,669,875.35
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	263,669,875.35	00.00	263,669,875.35
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	263,669,875.35	00.00	263,669,875.35
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	85,366,792.72	00.00	85,366,792.72
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	349,036,668.07	00.00	349,036,668.07

1.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	800,253,200.00	735,399,125.35	64,854,074.65	91.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	800,253,200.00	735,399,125.35	64,854,074.65	91.9
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	531,822,724.65	466,968,650.00	64,854,074.65	87.8
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	268,430,475.35	268,430,475.35	00.00	100.0
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	386,958,729.20	386,958,729.20	00.00	100.0
УРСГАЛ ЗАРДАЛ	800,253,200.00	735,399,125.35	64,854,074.65	91.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	800,253,200.00	735,399,125.35	64,854,074.65	91.9
Бараа үйлчилгээний бусад зардал	800,253,200.00	735,399,125.35	64,854,074.65	91.9
Бараа үйлчилгээний бусад зардал	800,253,200.00	735,399,125.35	64,854,074.65	91.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	268,430,475.35		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	284,036,668.07		

ХОЁР. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 65,000.0 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа 2 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 65,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч тус 2 төсөл арга хэмжээ дуусаагүй он дамжсан ба санхүүгийн тайланд нөөц дансанд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 82,000.0 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс, 2,000.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, зөрчлийг арилгах 80,000.0 мянган төгрөгийн 2 албан шаардлагыг хүргүүлсэн.

2.1 Төлбөрийн акт

2.1.1. Нийтийн эзэмшлийн талбай засаж сайжруулах ажлыг иргэнтэй 20,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн ба ХХОАТ-т 2,000.0 мянган төгрөгийг суутгасан боловч орон нутгийн төсөвт төлөөгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6-д "Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хувь хүний орлогын албан татварт суутгасан 2,000.0 мянган төгрөгийг ОНХС-аас Галуут сумын ХХОАТ-ын дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2.2 Албан шаардлага

2.2.1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа 20,000,000 (хорин сая) төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгосон, гэрээний хугацаа дууссан байхад байхад ажил хийгдэж дуусаагүй, ажлыг хүлээж аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Иргэний хуулийн 350 дугаар зүйлийн 350.1 "Ажил гүйцэтгэгч нь дараах үүрэг хүлээнэ", 350.1.1 "Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх", Талуудын хооронд байгуулсан "ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ногоон байгууламжийн ажилд хамтран ажиллах гэрээ"-ний 5.1, 10.1 дэх хэсгийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Гүйцэтгэгч аж ахуй нэгжээр ажлыг гүйцэтгүүлэн хүлээн авах, гэрээний үүргээ хэрэгжүүлэхгүй бол хуулийн байгууллагад шилжүүлэн зөрчлийг арилгах албан шаардлагыг өгөв.

2.2.2. Галуут сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 6/15 дугаар тогтоолоор орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 60,000.0 мянган төгрөгөөр өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлыг батлахдаа улаан хивэг 20,000.0 мянга, хорголжин 20,000.0 мянга, өвс татах зардал 20,000.0 мянган төгрөг гэж төсөвт өртгийг 3 хуваан баталсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжүүлэх, цаашид батлагдсан төсөвт өртгийг хуваахгүй байх, зөрчлийг арилгах албан шаардлагыг өгөв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг нотлох баримтын хамт Төрийн аудитын байгууллагад төлбөрийн акт, албан шаардлагад заасан хугацаанд ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ГУРАВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруула агуй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд хөрөнгийг бүртгэлгүй орхигдуулсан	1	65,000.0	1	65,000.0	-	-	1	65,000.0	-	-
Дүн	1	65,000.0	1	65,000.0	-	-	1	65,000.0	-	-

тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Төлбөрийн акт		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийтийн эзэмшлийн талбай засаж сайжруулах ажлыг иргэнтэй 20,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн ба ХХОАТ-т 2,000.0 мянган төгрөгийг суутгасан боловч орон нутгийн төсөвт төлөөгүй байна.	1	2,000.0	1	2,000.0	-	-
Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа 20,000,000 (хорин сая) төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгосон, гэрээний хугацаа дууссан байхад байхад ажил хийгдэж дуусаагүй, ажлыг хүлээж аваагүй байна.	1	20,000.0	-	-	1	20,000.0
Галуут сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 6/15 дугаар тогтоолоор орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 60,000.0 мянган төгрөгөөр өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлыг батлахдаа улаан хивэг 20,000.0 мянга, хорголжин 20,000.0 мянга, өвс татах зардал 20,000.0 мянган төгрөг гэж төсөвт өртгийг 3 хуваан баталсан байна.	1	60,000.0			1	60,000.0
Дүн	3	62,000.0	1	2,000.0	2	80,000.0

ДӨРӨВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1		1					
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1		1					

-----oO-----